Журмын 10б хавсралт

# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Зарцуулсан хөрөнгө /мян.төг/ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар / |
| Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | | |
| 1.1. | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твитер, инстаграм youtube суваг), мөн байгууллагуудын TV-ийн дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх. | 0.27 | Түгээсэн мэдээлэл, иргэдийн хандалтын тоогоор | 400-гаас доошгүй иргэн хамрагдсан байна. | Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласныг сайшаан дэмжиж, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүргийнхээ хүрээнд "Хужирт сум Авлигын эсрэг НЭГДЬЕ" үндэсний хэмжээний нөлөөллийн аяныг эхлүүлж нэгдсэн. Уг аянаар дамжуулан хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, авлигыг үл тэвчих үзэл, хандлагыг олон нийтийн дэмжлэг, оролцоотойгоор төлөвшүүлэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах, төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах, авлигын эрсдэлийг бууруулж, иргэдийг авлигын эсрэг шүгэл үлээхэд түлхэц үзүүлэх зорилготой сумын khujirt.ov.gov.mn вэбсайтад байршуулсан "Хужирт сум Авлигын эсрэг НЭГДЬЕ" үндэсний хэмжээний нөлөөллийн аяныг 104, Шударга ёс-Хөгжил дэвшилд "110" гомдол, мэдээлэл хүлээн авах утас хүлээн авах зурагт хуудсыг 230, бусад Авлигын эсрэг зурагт хуудсуудыг 389 иргэн үзсэн тандалттай байна.<br>Засаг даргын Тамгын газрын 4822 гишүүнтэй Facebook групп "Авлигын эсрэг НЭГДЬЕ" аянд нэгдэж, Cover зургийг шинэчилсэн.<br>Авлигын эсрэг зурагт хуудсыг төрийн байгууллагууд байгууллагын мэдээллийн самбар болон байгууллагын дотор орчинд иргэдэд ил харагдахуйц байршуулсан. Сурталчилгааны материалыг 389 иргэнд тараасан.<br>Үр дүнтэй -100% |
| 1.2. | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, | - | Шинэчилсэн мэдээллийн тоогоор | Сар бүр шинэчлэх | "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" гомдол, мэдээлэл хүлээж авах хайрцгийг Засаг даргын Тамгын газарт байршуулж ажиллаж байна. Ямар нэг гомдол, мэдээлэл ирээгүй байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах. | | | | Мөн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт иргэдэд түгээх авлигын эсрэг зурагт 4 янзын хуудсыг байршуулан түгээж байна.<br>Үр дүнтэй -100% |
| Зорилт 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | | | | | |
| 2.1 | Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх | 0.1 | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | Сургалт зохион байгуулсан байна | Шинээр томилогдсон болон мэдүүлэг анх гаргаж буй 6 албан хаагчдад Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, ХАСУМ, ХАСХОМ-ийг хэрхэн гаргах талаарх сургалтыг хийсэн. Мөн давтан сургалтыг 35 удирдах болон ХАСХОМ гаргагч эрх бүхий албан тушаалтанд зохион байгуулсан.<br>Үр дүнтэй -100% |
| Зорилт 3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | | | | | |
| 3.1 | Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээр бүрд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай мэдүүлгийг авсан байх. | | Мэдүүлгийн тоогоор | 20 доошгүй гэрээнд тусгасан байна | Төрийн албан хаагчдыг ёс зүйн, ашиг сонирхлын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх үүднээс Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй 23 ажлын гэрээнд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай мэдүүлгийг бөглүүлэн хяналт тавин ажилласан.<br>Тайлант онд нийтийн албан тушаалтан үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдал үүсээгүй.<br>Үр дүнтэй -100% |
| Зорилт 4. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | | | | | |
| 4.1 | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлэх / | 0.34 | Цахимжуулсан үйлчилгээ, зохион байгуулсан арга хэмжээний тоо | Цахим үйлчилгээний тоогоор | Сумын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 11 худалдан авах ажиллагаа цахим системээр явагдаж, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан, шалгараагүй хуулийн үндэслэлийг тухай бүр tender.gov.mn цахим хуудсанд байршуулсан.<br>Газар эзэмших эрхийн дуудлага худалдааг Газрын Цахим бирж mle.mn хаягт байршуулж 2023 онд нийт 4 нэгж талбарыг Цахим дуудлага худалдаагаар зохион байгуулсан.<br>Иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэх операторын үйлчилгээнд хамрагдах байгууллагын тоо нэмэгдсэнээр Хур системээс 102 төрлийн тодорхойлолт, лавлагаа, бичиг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | баримтын захиалгын үйлчилгээ нэмэгдсэн. 12 сарын байдлаар Хур системээр 187 иргэн лавлагаа, тодорхойлолтыг авч үйлчлүүлсэн.<br>Сумын хэмжээнд тоон гарын үсэг авах 3601 иргэнээс 1876 иргэн тоон гарын үсгээ авсан байна.<br>Засаг даргын Тамгын газрын албан ёсны цахим хуудас /khujirt.ov.gov.mn//-д 2023 оны турш нийт 30 гаруй мэдээ, мэдээллийг нийтэлж, 1444 хүнд, Засаг даргын Тамгын газрын албан ёсны Facebook хуудсанд тус бүр 400 гаруй пост оруулав. Тайлангийн хугацаанд ЗДТГ-ын Facebook хуудсанд орсон мэдээ мэдээлэл давхардсан тоогоор 10000 хүнд хүрсэн үзүүлэлттэй байна.<br>Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, Нийгмийн бодлогын болон Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн https://www.csc.gov.mn/, сумын khujirt.ov.gov.mn сайтад байршуулсан.<br>Үр дүнтэй -100% |
| 4.2 | Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах. | | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | Сэтгэл ханамжийн судалгаа авсан байна | Хэрэгжилт-0% |
| Зорилт 5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | | | | | |
| 5.1 | Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1 дүгээр улиралд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдад танилцуулах. | 0.27 | Төлөвлөгөө болон тайлан боловсруулж, танилцуулснаар | Нийт алба хаагчдад танилцуулсан байна | Сумын khujirt.ov.gov.mn вэбсайтын Ил тод байдал цэсийн Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэсгийн Авлигатай тэмцэх хөтөлбөрийн суманд хамаарах заалт хэсэгт 2023 онд 6 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг байршуулсан.<br>Төлөвлөгөөний биелэлтийг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн бөгөөд тайланг khujirt.ov.gov.mn вэбсайтын Ил тод байдал цэсийн Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэсгийн Авлигатай тэмцэх хөтөлбөрийн суманд хамаарах заалт хэсэгт байршуулсан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | Үр дүнтэй -100% |
| 5.2 | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүрэм журам, ёс зүйн дүрэм, зөвлөмжийг хэрэгжүүлэх. | - | Хэрэгжүүлсэн арга хэмжээгээр | Ёс зүйн зөрчил гараагүй байна. | Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн 1, 3, 4 дүгээр Цэцэрлэгүүд "Ёс зүйн зөвлөл"-ийг шинэчилж, төрийн 8 байгууллагын ёс зүйн зөвлөл жилийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилласан бөгөөд төрийн албан хаагчийг хуулиар хүлээсэн нийтлэг үүрэг, нийтлэг эрхээ хэрэгжүүлж ажиллах нөхцөл бүрдсэн бөгөөд ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн албан хаагч гараагүй. Төрийн албан хаагчтай холбоотой ёс зүйн гомдол, санал ирээгүй.ёс зүйн зөвлөлд төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой ирсэн өргөдөл, гомдол бүртгэгдээгүй.<br>Үр дүнтэй -100% |
| Зорилт 6. Байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах | | | | | |
| 6.1 | Эрүүгийн хуулийн авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй зүйл заалтад орсон өөрчлөлтийн талаар аймгийн Прокурорын газар, авлигын эсрэг сургагч багш нарын хамтран зохион байгуулах сургалтад төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудыг сургалт, мэдээлэл өгч, зөвлөмж, чиглэл хүргүүлэх. | 0.1 | Зохион Зохион байгуулсан сургалтын тоо байгуулсан сургалтын тоогоор | 20 доошгүй удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан | Аймгийн Прокурорын газар, Хууль зүйн хэлтсээс хамтран зохион байгуулсан Эрүүгийн хуульд авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбогдох зүйл заалтад орсон өөрчлөлтийн талаарх сургалтад төрийн байгууллагын 22 удирдах, гүйцэтгэх албан тушаалтан хамрагдсан.<br>Удирдлагын академиас явуулсан Төрийн албан хаагчдад зориулсан "Авлигаас ангид төрийн алба" 1-р түвшингийн цахим сургалтад Сургуулийн өмнөх боловсролын 3-р цэцэрлэгийн 10 багш, албан хаагчид хамрагдсан.<br>Үр дүнтэй -100% |
| 6.2 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжид заасан хориглолт хязгаарлалт зөрчсөн томилгоо, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө, орлогын мэдүүлгийн хугацаанд | | Хуулийн хугацаанд хүргүүлсэн байдлаар | Тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн 2.2 дахь заалтыг үндэслэн тус Тамгын газарт нэн яаралтай байсан Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан мэргэжилтэн, Нийгмийн бодлогын мэргэжилтний сул ажлын байр дээр 2 иргэнтэй Хөдөлмөрийн гэрээ ажиллаж байсныг энэ оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс чөлөөлсөн.<br>Хууль бус томилгоо хийгдээгүй.<br>Шинээр томилогдох 3 албан хаагчийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газраар хянуулж, дүгнэлтийг үндэслэн томилсон. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хяналт тавьж, тайланг хүргүүлэх. | | | | Сумын хэмжээнд ХАСХОМ мэдүүлэх 51 эрх бүхий албан тушаалтан, албан хаагч, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид хуулийн хугацаанд мэдүүлгээ гаргасан.<br>Үр дүнтэй -100% |
| 6.3 | Авлигын эсрэг сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хүүхэд залуучуудад хүргэх ажлыг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах | | Сургалтад хамрагдсан иргэн, хүүхэд залуучуудын тоогоор | 350 | Удирдлагын академиас явуулсан Төрийн албан хаагчдад зориулсан "Авлигаас ангид төрийн алба" 1-р түвшингийн цахим сургалтад Сургуулийн өмнөх боловсролын 2-р цэцэрлэгийн 10 багш, албан хаагчид хамрагдсан.<br>Тодорхой үр дүнд хүрсэн-70% |
| ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ-88% | | | | | |

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА Д.БАТБАЯР

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА З.ЦЭЦЭГМАА